



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУРААНГУЙ

Огноо: 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр
Хурал болсон газар: Гадаад харилцааны яам

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

Монголын Мянганы сорилтын сан /Монголын МСС/-ийн Удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаар дор дурдсан 5 асуудлыг хэлэлцэж, харгалзах шийдвэрийг батлав. Үүнд:

1. Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн анхдугаар хуралдааны тэмдэглэлийг Удирдах зөвлөлийн гишүүд санал нэгтгэйгээр батлав.
2. Монголын МСС-ийн ажилтнуудтай байгуулах стандарт Хөдөлмөрийн гэрээний төслийг Удирдах зөвлөлийн гишүүдэд танилцуулсны дараа Хөдөлмөрийн гэрээг зарчмын хувь дэмжин санал нэгтгэйгээр батлав.
3. Монголын МСС-ийн Гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтын үр дүнг сонсож, Удирдах зөвлөлийн гишүүд санал нэгтгэйгээр Гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтын тайланг хүлээн зөвшөөрч, холбогдох саналыг АНУ-ын Мянганы Сорилтын Корпорацид уламжлахаар тогтов. Мөн сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигч Э.Содонтогостой Хөдөлмөрийн гэрээний нөхцөл, шаардлагын талаар харилцан тохиролцож гэрээ байгуулахыг Удирдах зөвлөлийн даргад зөвшөөрөв.
4. Монголын МСС-ийн Нууцлалын талаар баримтлах бодлогыг Удирдах зөвлөлийн гишүүд санал нэгтгэйгээр батлав.
5. Монголын МСС-ийн Ашиг сонирхлын зөрчлийн талаар баримтлах бодлогыг Удирдах зөвлөлийн гишүүд санал нэгтгэйгээр батлав.

МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН